

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ  
“ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ-ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИ”  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ГАРАХ ЗӨВЛӨМЖ**

**Мал эмнэлэгийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:**

1. Мал эмнэлгийн эм бэдмэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол улсын засгийн газар, тусгайлан тогтоол гаргах нь зүйтэй байна Энэхүү тогтоолд :

1. Олон жилийн үе шаттай судалгаа шинжилгээний технологи нь буй болсон дотооддоо үйлдвэрлэж, эх орны хэрэгцээг бүрэн хангах боломжтой монгол эрдэмтдийн оюуны бүтээл-малын эм бэлдмэл, вакцин, оношлуурыг үйлдвэрлэх ажлыг үндэсний Эрдэмтэд болон үйлдвэрлэгчиддээ даатган жил бүр гадаад орноос малын эм бэлдмэл, вакцин, оношлуур ,ариутгал халваргүйтгэлийн бэлдмэл худалдан авахад зарцуулдаг валютын ( барагцаалбал 200 орчим тэрбум төгрөгтэй тэнцэх) нөөцийг дотооддоо үлдээж зах зээлээ импортын хараат байдлаас сэргийлэх;

2. Үндэсний үйлдвэрлэлийг энэ салбарт хөхүүлэн дэмжиж, эх оронд үйлдвэрлэж чадаж байгаатай адил үйлчилгээтэй эм бэлдмэл, вакцин, оношлуурыг гаднаас импортлохыг эдийн засгийн болон бусад зохицуулалтаар хязгаарлах ;

3. Мал, амьтны эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдлыг эрс сайжруулахад нэн шаардлагатай шинжлэх ухааны үндэслэл, арга технологийг боловсруулах чиглэлүүдээр томоохон төслүүдийг эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд үүрэг даалгавар болгон өгч хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг шуурхай зохион байгуулах;

2. Хүнсний аюулгүй байдлын чиглэлийн лабораториудыг өндөр хүчин чадалтай багаж тоног төхөөрөмжөөр хангахаас гадна тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах урсгал зардал эм урвалж, орон тооны мэргэшсэн техникийн ажилтан ажиллуулахад шаардагдах зардлыг бодитойгоор тусгаж өгөх;

3. Хараат бус хүнсний аюулгүй байдлын чиглэлээр мэргэшсэн лабораториудад итгэмжлэгдэх лабораториудыг төрөлжүүлэн хөгжүүлэхэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх;

4 .Мал эмнэлгийн хүрээлэнгийн судлаачдын олон жилийн судалгааны үр дүн болох ховор нян, вирус эгэл биетний омог өсгөврүүд, эрүүл эсийн өсгөвөр, үнэ цэнэтэй дээж материалууд туршилтын эрүүл мал, амьтан олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрөөр нийлүүлсэн асар өндөр үнэтэй, мэдрэг багаж тоног төхөөрөмжүүдийн арчилгаа, үйлчилгээний зардлыг хөдөө аж ахуй, хүнсний салбарын эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд үр дүнд суурилсан хэлбэрээр олгодог болох;

Эдгээр арга хэмжээнүүдийг шуурхай авч хэрэгжүүлсэнээр Монгол улсын мал аж ахуй (70 гаруй сая мал сүрэг), мал эмнэлгийн салбар (малын эмч, малчид) Үндэсний үйлдвэрлэлийн зохион бүтээж буй болгосон судалгаа туршилтаар баталгаажсан, хүнсний аюулгүй байдлын эрсдэл багатай эм, бэлдмэл, вакцин,

оношлуураар бүрэн хангагдана. Ингэснээр энэ чиглэлээр гадаад орны хараат байдал арилж, эдийн засаг, бизнесийн хувьд бие даан, Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдлын нөхцөл байдал эрс сайжирч, эрдэмтдийн оюуны бүтээл зах зээлийн эргэлтэд орох зэрэг олон эерэг өөрчлөлтүүд гарч эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн гинжин хэлхээ бэхжиж, Монгол улсад инновацийн тогтолцоо, үндэсний үйлдвэрлэл хөгжихөд бодит нөлөө үзүүлнэ.

### **Мал аж ахуйн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:**

1. Тэжээлийн ургамлын үрийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, төрөлжсөн үрийн аж ахуйг байгуулан, үрийн улсын хэрэгцээг хангаж, үрийн импортыг 30-40%-иар бууруулах
2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ган хүйтэнд тэсвэртэй тэжээлийн ургамлын шинэ сорт, таримал хэлбэр бий болгож, таримал тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулан, цөлжилтийн сааруулах
3. “МАЛЫН ТЭЖЭЭЛ” хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэн, дотоодын сүүний хэрэгцээг ханган, махны экспортыг нэмэгдүүлэх

### **Ургамал хамгааллын шинжлэх ухааны салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:**

- 1 Ургамал Хамгааллын Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгийн “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын лаборатори”-уудыг улам чадавхижуулж, бэхжүүлэх
- 2 Пестицид, бордооны үлдэгдэл, агууламжийг судлан тогтоодог судалгааны лабораторийг чадавхижуулах /учир нь одоогоор ажиллаж байгаа ганц лаборатори нь 100 хувь нөөц бололцоогоо дайчлан ажиллаж байгаа ч улсын хэмжээний нийт хэрэглээний 10 хувь ч хүрэхгүй пестицид, бордооны судалгааг хийж байгаа/
- 3 Улсын хэмжээнд гадаад, дотоод хорио цээртэй организмын судалгаа хийх “Биоаюулгүйн нэгдсэн лаборатори” байгуулах
- 4 Эрдэмтдийн гаргасан “Ургамал хамгаалах биобэлдмэл”-үүдийг үйлдвэрлэх үйлдвэр, цехийг яаралтай байгуулж, ашиглалтанд оруулах /Ингэснээр гаднаас 100 хувь авч хэрэглэж байгаа химийн пестицидийн хэрэглээг бууруулж, эрүүл, чанартай, органик хүнсээр хангах, мөн бэлчээр-ойн хөнөөлт организмтай байгаль, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй биологийн аргуудыг нэвтрүүлэх, гадагшаа урсах валютын урсгалын зогсоох өндөр ач холбогдолтой юм/
- 5 Эрдэм шинжилгээний байгууллагын одоогийн материаллаг бааз, боловсон хүчин, санхүүгийн хангамжийг эрс нэмэгдүүлэх
- 6 Судлаач нарын нийгмийн асуудлыг сайжруулах шийдвэрүүдийг гаргаж, бодитой хэрэгжүүлэх

## **Газар тариалангийн шинжлэх ухааны салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:**

1. Монгол улсын хэмжээнд үр тариа, төмс, хүнсний ногоо, тос, тэжээлийн таримал ургамлын нутагшсан сортын элит үр, жимс жимсгэний таримлын нутагшсан сортын тарьц, суулгац үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг бүрэн хангах үрийн аж ахуйн үндэсний тогтолцоог хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт, бүтэц зохион байгуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, Үүнд:

Эрдэм шинжилгээний байгууллагын одоогийн материаллаг бааз, боловсон хүчин, санхүүгийн хангамжийг эрс нэмэгдүүлэх замаар бүх төрлийн таримал ургамлын нутагшсан сортын анхдагч үрийн аж ахуйг өргөжүүлж супер элит үр үйлдвэрлэх. Харин Элит болон Репродукцын эхний үеийг мэргэшсэн үр үйлдвэрлэгч аж ахуйд үйлдвэрлэх улмаар Аж ахуй нэгжүүд дотоодын үрийн аж ахуйг хөгжүүлэн 2-4 репродукциар тариалалт хийх бүтцээр үр үйлдвэрлэлийг улсын хэмжээнд зохион байгуулах замаар үрийн хангамжыг эрс сайжруулж, нөөц бүрдүүлэх,

2. Үр тариа, төмс, хүнсний ногоо, тос, тэжээлийн ургамал, жимс жимсгэний таримлын нутагшсан сортын супер элит үр, элит үр болон I-р Репродукцийн үр үржүүлж байгаа аж ахуй нэгжид урамшуулал олгох замаар үр үйлдвэрлэлийг дэмжих,
3. Үрийн аж ахуйн зориулалтын техник, тоног төхөөрөмж, үтрэм, агуулах байгуулах, шинэчлэхэд зориулж үрийн аж ахуйнуудад урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох,
4. ХХААХҮЯ-ны бүтцэд үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээл, тосны болон жимс жимсгэний таримал ургамлын сорт сорилт, үр үржүүлгийн төвүүдийг сэргээн байгуулах. Үүний үр дүнд таримал ургамлын сортуудыг экологийн янз бүрийн бүсд сорьж бүтээмж өндөр, тэсвэртэй шинэ сортууд олноор нутагшуулж, анхан шатны үр үржүүлэх боломж бүрдэнэ.
5. Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн таримал ургамлын генетик нөөцийн цуглуулгыг төрийн мэдэлд, хамгаалалтанд авч Монгол улсын Ургамлын Үндэсний Генбанк болгон өргөжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх замаар шаардлагатай лабораториуд байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах, боловсон хүчний хангамж, чадавхийг эрс нэмэгдүүлэх,
6. Ургамал газар тариалангийн хүрээлэнд нэг наст таримал тэжээл, тосны ургамлын судалгааны нэгж байгуулж тариалангийн сэлгээнд улам нэмэгдэж байгаа тэжээл, тосны таримлын судалгааг эрчимжүүлж тохиромжтой сортын тоог нэмэгдүүлж тогтвортой ургац авах нөхцөл бүрдүүлэх,
7. Таримал ургамлын сортын физиологийн үйл ажиллагаа, амьсгалалт, хооллолт, фотосинтезийн процессыг нягт судалсны үндсэн дээр ган, халуунд тэсвэртэй, ургацын болон чанарын өндөр чадавхитай сортын загварыг гаргаж селекцийн практикт нэвтрүүлэх, мутацийн болон биотехнологи, молекул генетик, физиологийн судалгааны технологийн дэвшлийг бүх төрлийн таримал ургамлын селекцийн ажилд нэвтрүүлж шинэ сорт бүтээх хугацааг богиносгох судалгааны чиглэлийг эрс нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Нэн шаардлагатай байгаа

молекул генетикийн, физиологийн , биохими-технологийн лабораториуд байгуулах,

8. Тариалангийн сэлгээнд тохиромжтой үр тариа, тос, тэжээл болон хүнсний ногооны, таримлуудын нэр төрлийг олшруулах, шинэ таримал ургамлыг тариалах, ургуулах орчин үеийн дэвшилтэт агротехнологийг эзэмших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх судалгааны чиглэлийг нэмэгдүүлэх,
9. Тариалангийн талбайн одоогийн ашиглалтыг эрс сайжруулах болон судалгааны үр дүнд үндэслэн шинээр тариалангийн зориулалттай талбайг өргөжүүлэх арга замаар улсын хэмжээнд тариалангийн эргэлтийн талбай хэмжээг нэмэгдүүлэх,

### **Хүнс үйлдвэрлэлийн шинжлэх ухааны салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:**

Монгол улс төрийн бодлогодоо мэдлэгт тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэх, шинжлэх ухаан, инновацийг хөгжүүлэх, бодлогын баримт бичиг, хуулийн төслүүдийг боловсруулан гаргаад байна.

Судалгаа шинжилгээ, их дээд сургууль, мэргэжлийн сургалтын байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлэхийн тулд дараах ажлуудыг шат дараатай зохион байгуулах саналтай байна. Үүнд:

1. Шинжлэх ухаан, өндөр технологи, инновацийг хүнсний салбарт үр дүнтэй хөгжүүлэхийн тулд төр, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, нөөц боломжийг илрүүлэх, мэдээлэлээр хангах шаардлагатай байна.
2. Хүн амын эрүүл мэндийн байдлыг дэмжих, сайжруулахын тулд хүн амын хүнсний бодит хэрэглээ, шим тэжээлийн нөхцөл байдлын судалгааг 5 жил тутам хэрэгжүүлж, нотолгоонд суурилан хүн амын хэрэглээ ба үйлдвэрлэлийн хэмжээг төлөвлөдөг болох
3. Монголчуудын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний химийн найрлагын мэдээллийн санг бий болгох, олон улсын сүлжээнд нэгдэх
4. Төрөөс хүнсний асуудлыг судалгаанд суурилан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах, шинээр байгуулах болон өргөтгөх хүнсний үйлдвэрийн зураг төслийг мэргэжлийн байгууллага, бэлтгэгдсэн инженер технологичдоор хийлгэх.
5. Хүн ардад эрүүл амьдралын эх болсон хоол шим тэжээлийн боловсрол олгох ажлыг цэцэрлэг, сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах, хэрэгжүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх ажлыг бүх шатанд тодорхой хөтөлбөр төлөвлөгөөтэйгээр зарцуулах хөрөнгийн асуудлын хамт шийдвэрлэн зохион байгуулах.
6. Хүнсний бодлогыг нэгдмэл болгохын тулд түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үеийн технологийн горим, үйлдвэрлэлээс тээвэрлэх, худалдаанд түгээх, хадгалах, хэрэглээний заавар, сав баглаа боодол, шошго, хэрэглэх арга болон хэрэглэгчдэд очих хүртэл бүх үе шатыг систем динамикаар судлан тогтоож цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх

7. Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд судалгааны бие даасан хүрээлэн байгуулан тоног төхөөрөмж, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх.
8. Хүнсний чиглэлээр суралцсан боловсон хүчнийг өндөр хөгжилтэй орнуудын их дээд сургууль, судалгааны байгууллагуудад ахисан түвшний сургалт, судалгаанд тодорхой нарийсгасан чиглэлээр дадлагажуулан, шинжээч судлаачдыг үе шаттай төлөвлөлттэй бэлтгэх.

### **Хүнсний аюулгүй байдлын бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд:**

1. Хүнсний хангамж, үйлдвэрлэлийн эрх зүйн орчныг шинэчлэх.
2. Хүнсний бодлого тодорхойлох, шийдвэр гаргах төдийгүй гүйцэтгэх бүх түвшинд хүнсний мэргэжлийн туршлага, ур чадвартай мэргэжилтэн ажиллуулах, тэдний мэргэжил дээшлүүлэх, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх. /сүүлийн үед хэт улстөржиж мэргэжлийн бус хүмүүс ажиллах болсноос алдаа, доголдол ихээр гарч байна./
3. Төрийн өмчийн эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүнсний хангамжийг хуулийн үр ашигтай, оновчтой хэлбэрээр хэрэгжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд холбогдох стандарт, зохистой дадал, улмаар НАССР нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, итгэмжлэлийн үйл ажиллагааг үр дүнгийн хяналттай хэрэгжүүлэх
4. Хүнсний бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний санамсаргүй хяналтын тогтолцоо бий болгох, жил тутам лабораторийн хяналт хэрэгжүүлэх өртгийг улсын төсөвт тусгах

### **Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухааны чиглэлээр авах арга хэмжээнүүд:**

1. Хөнгөн үйлдвэрийн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны лабораторийн бага ж тоногтөхөөрөмжийг олон улсын түвшинд хүргэнөргөжүүлэх, шинэ материалын судалгаа, хэрэглээний шаардлагад нийцүүлэндизайныг хөгжүүлэх чиглэлд бэхжүүлэх(ойролцоогоор 2 сая доллар), гадаад хамтынажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (жилбүр "Монгол ноолуур" олон улсын эрдэмшинжилгээний хурлыг ерөнхи йлөгчийн ивээл дорзохион байгуулах),
2. Залуу судлаачид болон ахисан түвшиний сургалтыг гадаадын өндөр хөгжилтэй улсуудад тодорхой зорилттой сургах ажлыг шат дараатайзохион байгуулан дэмжих, шинэ технологи, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх гараанызардлыг олгох
3. Өндөр технологи хөгжүүлэх дараах судалгаа, эрдэм шинжилгээний ажил, инновацийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг бодлогоор дэмжинэ:  
Малын гаралтай түүхий эдийн онцлогшинжийг генийн түвшинд тодорхойлох судалгаа, брэнд бүтээгдэхүүний шинэ технологи боловсруулалт (Газар зүйн заалттай бүтээгдэхүүнийг хөгжүүлэх)
4. Шинэ материалын судалгаа (уургийн гаралтай биоматериал, ургамал болон модлог, түүний хаягдал биомассыг ашиглан шинэ материал гаргах судалгаа), боловсруулалт
5. Хэрэглэгчийн хэрэглээ (Хувцас, гутал, хэвлэл, модон бүтээгдэхүүн)–ний онцлог шинж байдлын болон тааламжтай байдлын судалгаа, хөгжүүлэлт

6. Монгол хүний биеийн хэмжилзүйн судалгаагтодорхой үечлэлтэй явуулж онцлог шинжчанаар өөрчлөлтийг шинжлэх ухааныүндэслэлтэй явуулах, өгөгдлийн санбүрд үүлэх